

БАТЛАВ.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д.САРАН-ЭРДЭНЭ*



ЗУУНМОД СУМЫН 1-Р БАГТ ХӨГЖИЛ ХОТХОНЫ АВТО ЗАМ, ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН  
АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар: 06/24

2024.09.23

Зуунмод сүм

Зураг төсөл боловсруулах үндэслэл	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлийн хөрөнгө оруулалтаар 2024 оны жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалтад Хөгжил хотхоны зам талбайн тохижилтын ажлын зураг төсөл боловсруулахаар хөрөнгө тусгагдсан.
Байршил, инженерийн шугам сүлжээний одоогийн байдал	Зуунмод сумын 1-р баг хөгжил хотхон. 134 айлын амины орон сууц, 40 айлын нийтийн орон сууцны барилгатай. 18-р байр нийт 60 айл өрхтэй. - Авто зам: Хөгжил хотхон 1.1км, 18-р байр орчмын 0.11 км авто зам, авто зогсоолтой. Явган зам гэрэлтүүлэгтэй. Нийт 6.1 га талбайд байрлах суурьшлын бүс байна. - Инженерийн шугам сүлжээ: Дулаан хангамжийн шугам сүлжээ, цэвэр усан хангамжийн шугам сүлжээ, ариутгах татуургын шугам сүлжээ, цахилгаан хангамжийн 10/0,4кВ-ын дэд станц, цахилгаан хангамжийн шугам сүлжээ
Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ	Зуунмод сумын 1-р баг хөгжил хотхон, 18-р байр орчмын суурьшлын бүсийг хамруулан төлөвлөлт хийн зураг төсөл боловсруулна. Авто зам: <ol style="list-style-type: none"><li>Хөгжил хотхоны одоо байгаа 1,06 км авто замын засварлан шинэчлэх ба шинээр 96м авто нэмж байгуулахаар төлөвлөнө.</li><li>18-р байрны 152м авто зам, зогсоол нэмэгдүүлэн төлөвлөнө.</li><li>Авто замын 2 талд 1,5м өргөнтэй явган замыг шинэчлэн байгуулахаар төлөвлөнө.</li><li>Авто зам дагуу ус зайлцуулах төмөр бетон суваг төлөвлөнө.</li><li>Хорооллын одоо байгаа гэрэлтүүлгийн шонтой стандартад нийцүүлэн нэмэгдүүлэх арга хэмжээг авахаар зураг төсөлд төлөвлөнө.</li><li>Хорооллын гадна болон доторх авто зам төлөвлөхдөө одоо байгаа инженерийн хангамжийн шугам сүлжээ, шинээр байгуулагдаж байгаа үерийн ус зайлцуулах</li></ol>

	<p>суваг, барилга байгууламжтай уялдуулан төлөвлөх, отглолцож байгаа хэсэгт хоолой, замын хучилтын хийцийг хавтангаар төлөвлөх</p> <p>7. Авто замын тэмдэг тэмдэглэгээ стандартын дагуу төлөвлөх</p> <p>8. Авто зогсоол, явган зам талбайг авто замын зураг төсөлд тусгана.</p> <p>9. Нийт 8000м2 талбайд тохижилтын ажлын зураг төсөлд боловсруулах бөгөөд 20 гражийн барилгыг буулган чөлөөлж, бага, дунд, ахмад настнуудын тоглоом, спорт талбай төлөвлөнө.</p> <p>10. Ногоон байгууламж авто зам дагуу төлөвлөх бөгөөд спорт тоглоомын талбайд төлөвлөнө.</p>
Зураг төсөл боловсруулах ажлын үе шат	<p>1 үе шаттай.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эх загвар зураг /Төлөвлөлтийн эхний хувилбар боловсруулан захиалагчид танилцуулан захиалагчтай зөвшөөрөлцөх/</li> <li>- Ажлын зураг /Авто зам, ногоон байгууламж, спорт, тоглоомын талбай/</li> <li>- Ажлын төсөв боловсруулах /Төсвийн Естиматор_ПРО/</li> </ul>
Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Монгол Улсын хуулиуд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Авто замын тухай хууль</li> <li>- Газрын тухай хууль</li> <li>- Бусад хууль тогтоомж</li> </ul> <p><u>Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зуунмод хотын сумын төвийн хөгжлийн өрөнхий төлөвлөгөө</li> <li>- Бусад.</li> </ul> <p><u>Норм норматив, стандарт:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Авто замын ажлын зургийг Монгол улсад мөрдөх буй Авто зам, гүүрний зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ тооцох аргачлал 2018, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, "Авто зам төсөөлөх" ЗЗБД22-004-2016, "Авто замын гүүр ба хоолой төсөөлөх" БНБД 32-02-12, Монгол улсын стандарт Авто замын салбарт мөрдөх стандартын замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хашилт чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014, MNS 4597:2014, MNS 4159:2014, MNS 4980:2014, Явган хүний зам, талбайн төлөвлөлт. техникийн шаардлага MNS 6808: 2019, "Зам замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох заавар" ЗЗБНБД81-013—2019, "Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм" БНБД 81-25-07, "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам", Нийтийн тээвэр замналын</li> </ul>

	<p>зогсоол. Ангилал. Техникийн шаардлага MNS 5879:2012 бусад холбогдох норм дүрм стандартуудыг үндэслэх, "Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-04);</li> <li>- 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил БД 11-106-08;</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм ба дүрэм /БНБД 21.02.02/</li> <li>- "Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил" БД11-105-06 (БХБ-ЫН Сайдын 2006 оны 116 дугаар тушаал);</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм, заавар, стандарт</li> </ul>
Баримт бичгийн бүрдэл	<p><u>Суурь судалгаа:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зураг төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбилцолын нэгдсэн тогтолцоо масштаб M1:500 дэвсгэр зураглал хийх</li> <li>- Инженер-геологийн судалгааны дүгнэлт шинээр хийнэ.</li> <li>- Газар олголт, баригдсан барилга байгууламжууд төлөвлөгдж байгаа барилга байгууламжийн уялдаа</li> </ul> <p><u>Ажлын зураг:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Өндөржилт, инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын зураг</li> <li>- Инженерийн шугам сүлжээний давхцал хэсэгт авах арга хэмжээ</li> <li>- Авто зам, явган замын ажлын зураг төсөл</li> <li>- Тайлбар бичиг</li> <li>- Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж, спорт талбай, ахмадын амрах талбай, хуухдийн тоглоомын талбайн ажлын зураг</li> <li>- Гэрэлтүүлгийн ажлын зураг</li> </ul> <p><u>3 хэмжээст зураглал, анимэйшн:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зам, талбайн төлөвлөлт зураглал</li> <li>- Хөдөлгөөнт анимэйшн видео</li> </ul> <p><u>Ажлын төсөв</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төсөв /эстиматор про программаар хийсэн байх ба үүнээс тоо хэмжээг тусад нь гарган хавсаргана. / 2 хувь /</li> </ul> <p><u>Магадлалын дүгнэлт, эх хувь болон хуулбар хувь 2%</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын зураг, төсөв, геологийн дүгнэлт, бусад материалыг 2 хувь захиалагчид хулээлгэн өгнө. / эх хувь1ш, хуулбар1ш</li> <li>- Тоон байдлаар DVD-нд хуулбарлан ирүүлнэ. /Төлөвлөлтийн зураглалыг Auto CAD-aap, 3 хэмжээст зургийг тусгай программ/Sketch up, Lumion, 3d MAX-/aap бусад зургууд болон төсвийг PDF хэлбэрээр ирүүлнэ./</li> </ul> <p><u>Авто замын зураг төслийн бүрэлдэхүүн:</u></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Бичиглэлийн материал: <ul style="list-style-type: none"> <li>- Тайлбар бичиг</li> </ul> </li> </ol>

	<ul style="list-style-type: none"> <li>- Техникийн шаардлага</li> <li>- Техникийн нэхцөл</li> <li>- Ажлын зураг</li> <li>- Геологийн судалгааны дүгнэлт</li> <li>- Геодези, хэмжилтийн ажлын тайлан</li> <li>- Ажлын нэр төрөл, тоо хэмжээ</li> <li>- Барилгын ажлын төсөв</li> </ul> <p><b>2. Төлөвлөлтийн зураглал:</b></p> <p><b>Зам талбайн ажлын зураг:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Авто зам талбайн төлөвлөлтийн ажлын зураг м1:500; м1:100;</li> <li>- Авто замын өндөржилтийн ажлын зураг м1:500; м1:100;</li> <li>- Картограмм м1:500;</li> <li>- Авто замын хөндлөн огтлол м1:100; м1:1000;</li> <li>- Авто замын дагуу огтлол м1:100; м1:1000;</li> <li>- Явган замын хийцэл м1:500;</li> <li>- Хөдөлгөөн зохион байгуулалтын ажлын зураг м1:500; м1:100; м1:50;</li> <li>- Ногоон байгууламжийн ажлын зураг м1:500; м1:100; м1:50;</li> <li>- Явган зам талбайн ажлын зураг м1:500; м1:100; м1:50;</li> </ul> <p><b>Инженер шугам сүлжээ ажлын зураг:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Инженерийн шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт м1:500;</li> <li>- Өндөржилт м1:500;</li> </ul>
Шийдвэрлэх үндсэн асуудлууд	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооллын өндөржилт, инженерийн бэлтгэл арга хэмжээг төлөвлөж шийдвэрлэх</li> <li>- Үерийн ус зайлцуулах суваг, одоо байгаа болон төлөвлөгдөж байгаа шугам сүлжээний давхцал арга хэмжээ авч, зураг төсөлд тусгах</li> </ul>
Эдийн засгийн тооцоо, төсөв	Талбайн ажлын төсвийг эстиматор про программаар хийж, магадлалаар баталгаажуулна.
Төслийн онцгой нэхцөл	<p><u>Авто замын байгууламж:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх, зам барилгын ажлын үед геометр хэмжээг хангах, хэмжилтийн төсөл, даалгавар боловсруулах. Автозам, уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажлын зурсас газарт орсон түр реперийг байгуулж, барилгын ажлын бэлтгэл хангах. Геодезийн хяналтын инженерээр хянуулж баталгаажуулах.</li> <li>- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрд хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох.</li> <li>- Автозам, уулзварын хөдөлгөөн зохион байгуулалтыг оновчтой төлөвлөх, уулзваруудад цэвэр үзэмжтэй хамгаалалтын төмөр хашлага төлөвлөх</li> <li>- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах ба зураг төслийг боловсруулахдаа холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн байх.</li> <li>- Авто зам, уулзвар болон авто зогсоолын ус зайлцуулах</li> </ul>

	<p>байгууламжийг цогц байдлаар шийдвэрлэх, замын дагуух гадаргуун ус зайлзуулах байгууламжийг орчноор нь тооцож шийдвэрлэх,</p> <p>- Авто зам, уулзварын ажлын нэгдсэн төсөвт өртөгт инженерийн байгууламжтай холбоотой объектуудын нүүлгэх, шилжүүлэх, буулгах зардлуудыг инженерийн байгууламжийн ажлын зураг боловсруулах туслан гүйцэтгэгч нарт анхааруулж тусгуулах. Мөн авто замын барилгын ажлын төсөвт түр барилга ба аж ахуйн бэлтгэл ажил, объект ашиглалтад оруулах, хог хаягдал цэвэрлэх, зурваст орсон геодезийн хатуу цэгийг шилжүүлж шинээр байгуулах, лабораторийн туршилт шинжилгээний ажлуудтай холбоотой зардлуудыг заавал тусгах.</p> <p><u>Ногоон байгууламж:</u></p> <p>Тариалах мод, бут, сөөг, нь тухайн орон нутагт дасан зохицсон, нутагшсан, төрөл зүйлийн биологийн онцлогт тохирсон үр суулгац байна. Үр суулгацыг тариалахад шаардагдах тухайн орон нутгийн хөрсний шинж чанар бүтцээс хамаарч хар шороо, элс, бууц, эрдэс бордоог агро техникийн шаардлагын дагуу төлөвлөх</p> <p><u>Бусад:</u></p> <p>Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээ орсон тохиолдолд инженерийн бэлтгэл арга хэмжээ, шугам сүлжээний одоогийн байдал болон төлөвлөлтийг нэг дэвсгэр зураг дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлонын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай.</p>
Зураг төсөл боловсруулах хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 3 сарын хугацаатай гүйцэтгэх ба магадлалаар хянуулах хугацаа орсон.
Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
Захиалагч байгууллага	Төв аймгийн Засаг даргын ЗДТГ, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
Гүйцэтгэгч байгууллага	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна.</p> <p>Авто замын зураг төсөл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.</p>
Зөвшөөрөлцөх байгууллага	Захиалагч болох Төв аймгийн ЗДТГ, ГХБХБГ, аймгийн ерөнхий архитектор, холбогдох байгууллагатай зөвшөөрөлцөх; Төлөвлөгөөний баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах;

Хянасан:

Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын

газрын дарга



Б.Насанжаргал

ЗУУНМОД СУМЫН 1-Р БАГТ ХӨГЖИЛ ХОТХОНЫ АВТО ЗАМ, ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН  
АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Боловсруулсан:

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга, аймгийн ерөнхий архитектор:

  
Д.Алтансүх

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлал хариуцсан мэргэжилтэн:

  
Б.Бат-Оргил

